МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.01.07 № хт/29

танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.МӨНХБАЯСГАЛАН ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Зарим төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газруудын сүүлийн 8 жилийн хугацаанд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн жагсаалт зэрэг мэдээллийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хариуг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон “Эрдэнэс Монгол” ХХК-аас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 18.. хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

000255000163

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 23 50,
Цахим шуудан: info@pcsp.gov.mn,
Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2024.12.18 № А-3/2324

танай _____-ны №_____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.СОЛОНГОО ТАНАА

Хүсэлт уламжлах тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас хавсралтаар ирүүлсэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн сүүлийн 8 жилийн хугацаанд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн жагсаалт, тэдгээрийн аудитын дүгнэлт, 2025 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлого, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөрийн мэдээллийг нэгтгэн ирүүлэх тухай албан бичиг ирүүлсэн.

Иймд “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаниудаас ирүүлсэн мэдээллийг хүргүүлж байна.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгаланд мэдээллийг уламжилж өгнө үү.

Холбогдох мэдээллүүдийг хавсаргав.

Хавсралт: ...7... хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132008638

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХОНГОН УЙЛДВЭРИЙН ЯАМ
ХӨДӨӨ АЖ АХУЙН КОРПОРАЦИ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
Дархан Юнайтед Арена, Олимпийн гудамж,
14 дүгээр баг, Дархан сум, Дархан-Уул аймаг, 45059
Утас: 7723 8888,
Цахим шуудан: center@agricorp.mn, info@agricorp.mn
Цахим хуудас: www.agricorp.mn

2024.12.13 № 01/1178
танай 2024.12.06-ны № А-1/2149 -т

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ

Хариу хүргүүлэх тухай

Танай ирүүлсэн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/2149 тоот албан бичигтэй танилцлаа. Хүсэлтийн дагуу тусгай сангийн болон "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн сүүлийн 8 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл хүргүүлж байна. "Тариалан эрхлэлтийг дэмжих сан", "Мал хамгаалах сан", "Хөдөө аж ахуйг дэмжих сан"-гуудад хэрэгжүүлж байсан дараах 5 төслийн "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК шилжүүлэн өр төлбөрийг барагдуулан ажиллаж байна.

1. 2003 оноос хэрэгжиж эхэлсэн "Мал хамгаалах сан"-гийн үйл ажиллагааг татан буулгаж, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 16 дугаар тогтоолоор "Мал хамгаалах сан"-гаас "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам", "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан"-д шилжүүлсэн хөрөнгө, өглөг, авлагыг "Хөдөө аж ахуйг дэмжих сан"-д шилжүүлсэнээр "Мал хамгаалах сан"-гийн 32,5 тэрбум төгрөгийн хөрөнгө, 13.1 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэл шилжүүлэн авсан. Энэ төлбөрийг 2020 оноос эхлэн Сангийн яаманд шат дараатай төлж 2023 онд төлбөрийн үлдэгдэлгүй бүрэн төлж барагдуулсан байна.

2. 2007 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн Монгол улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр намрын ургацаас хүнсний улаанбуудайн нөөц бүрдүүлэх, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын хангамж, үнийг тогтвортой байлгах зорилгоор 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан Монгол улсын "Сангийн яам", "Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам"-ны хоорондын гэрээгээр Монгол улсын сангийн нөөц хэлбэрээр байршуулах 30,3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 80,9 мянган тонн хүнсний буудайг хадгалах, хадгалуулах, түүнд хяналт тавих гэрээ байгуулан

ажиллаж ирсэн. Энэ төслийн хүрээнд гурилын үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах, хүнсний улаанбуудайн нөөцийг сэлбэн жил бүрийн ургацаас стандартад нийцсэн улаанбуудай нөөцлөх арга хэмжээнүүдийг авч ажиллан 2023 онд эргэн төлж төлбөрийг Сангийн яаманд төвлөрүүлсэн.

3. "Тариалан эрхлэлтийг дэмжих сан"-гаар дамжуулан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр худалдан авсан хөдөө аж ахуйн зориулалттай бага оврын трактор, түүний дагалдах иж бүрдлийг борлуулах, зээлийн эргэн төлөлтийг төвлөрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн хүрээнд гурван удаагийн трактор, хөдөө аж ахуйн машин, механизм болон хүлэмж, усалгааны систем, тоног төхөөрөмжийг 64,4 сая долларын зээл 2032 оны 07 дугаар сар хүртэл гэрээ байгуулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 647 аж ахуйн нэгж иргэнд зээлээр болон хөнгөлөлтөөр борлуулсан. Энэ хугацаанд 62,6 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдэж, 5 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмжийн үлдэгдэлтэй байна.

4. Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Үндэсний аян өрнүүлэх тухай 212 дугаар тогтоолын хүрээнд 2017 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн Монгол Улсын Засгийн Газрын 23 дугаар хуралдаанд Оросын Холбооны Улсын Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр "Газар тариалангийн техникийн шинэчлэл" төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу Хүнс, Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Сайдын 2017 оны 06 дугаар сарын 19-ний А-77 дугаар Төсөл хэрэгжүүлэх тухай тушаалыг үндэслэн хэрэгжилтийг хангахаар Техник, тоног төхөөрөмжийг дамжуулан түрээслэх үнэ, нөхцөл тогтоох тухай Хүнс, Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн сайдын 2017 оны А-107 тоот, 2018 оны А-133 тоот, 2019 оны А-288 тоот тушаалаар "Ди Би Эм лизинг" ХХК-тай санхүүгийн түрээсийн 4 удаагийн техник нийлүүлэх гэрээгээр 10 сая ам. Доллар, 8.3 сая еврогийн зээл бүхий төсөл хэрэгжүүлсэн. Энэ төслийн хүрээнд Оросын Холбооны Улсад үйлдвэрлэгдсэн 835 ширхэг газар тариалангийн техник, тоног төхөөрөмж авч давхардсан тоогоор 278 тариалан эрхлэгч аж ахуй нэгж, иргэдэд нийлүүлэн 18,4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого хийгдэж, одоогийн байдлаар 867,5 сая төгрөгийн өртөг бүхий 23 ширхэг техник үлдэгдэлтэй байна.

5. Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар, Монгол улсын Засгийн газрын хоорондын экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд "Трактор, хөдөө аж ахуйн машин, агуулах нийлүүлэх" төсөл хэрэгжүүлэхээр 2021 оны 8 дугаар сарын 31 -ний өдрийн Бүгд Найрамдах Беларсь Улсын Хөгжлийн банкны зээлийг Монгол улсын "Сангийн яам" "Хүнс, Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам"-дын

хоорондын гэрээгээр “Хөдөө Аж Ахуйг Дэмжих сан”-д 3,8 сая еврогийн зээлийг 2027 оны 10 дугаар сар хүртэл төлж барагдуулахаар эцэслэн байгуулсан. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд 10,5 тэрбум төгрөгийн төлөлт хийгдэж, 7,4 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ төслийн хүрээнд хөдөө аж ахуйн өндөр хүчин чадал бүхий 534 ширхэг техник, тоног төхөөрөмжийг газар тариалан эрхлэгчдэд зах зээлээс бага үнээр нийлүүлэхээр оруулж ирсэн ба 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 1,3 тэрбум төгрөгийн 39 ширхэг техник агуулахад үлдэгдэлтэй байна.

6. Компанийн 2025 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлого, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөр, бизнес төлөвлөгөө албажин батлагдсаны дараа хүргүүлэхээр төлөвлөж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЦОГТСАРАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЦЭНГЭЛ
ТАНАА

2024 12 10 366

Асуултын хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А-1/2151 тоот албан бичигтэй танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн ирүүлсэн дараах Асуултын хариуг хавсралтаар илгээж байна. Үүнд:

1. Сүүлийн 8 жилийн хугацаанд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалт, санхүүжүүлсэн мөнгөн дүнгийн дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээрийн зарцуулалтад хийсэн аудитын тайлангийн хамт;
2. Хуулийн этгээдийн өр төлбөрийн мэдээлэл, шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн болон шүүхийн шатанд буй хэрэг, маргааны дэлгэрэнгүй мэдээлэл, шүүхийг шийдвэрийг тус тус сүүлийн 8 жилийн хугацаагаар;
3. Улсын төсөвт төвлөрүүлж буй мөнгөн дүн, 2025 онд Улсын төсөвт төвлөрүүлсэн гүйцэтгэх орлогын даалгавар;
4. Ирэх онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүд, санхүүжүүлэх мөнгөн дүн зэргийн дэлгэрэнгүй;

Хавсралт 4. хуудастай

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.БАТСАЙХАН

№	Асуулт	Хариу тайлбар
1	Сүүлийн 8 жилийн хугацаанд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалт, санхүүжүүлсэн мөнгөн дүнгийн дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээрийн зарцуулалтад хийсэн аудитын тайлангийн хамт	Сүүлийн 8 жилийн хугацаанд аливаа нэгэн төсөл, хөтөлбөр санжүүжүүлээгүй болно.
2	Хуулийн этгээдийн өр төлбөрийн мэдээлэл, шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн болон шүүхийн шатанд буй хэрэг, маргааны дэлгэрэнгүй мэдээлэл, шүүхийг шийдвэрийг тус тус сүүлийн 8 жилийн хугацаагаар	Компанийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд тусгаснаар Аж ахуй нэгжийн орлогын албан татварын өр төлбөр 705.43 сая төгрөг байгаа бөгөөд дээрх өр төлбөрийг тайлант жилийн 4-р улиралд бүрэн барагдуулахаар ажиллаж байна. Манай компанид дээрхээс өөр аливаа нэгэн өр төлбөр байхгүй болно.
		1. Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн "Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай" 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 182/ШЗ2021/10607 тоот захирамжаар 428,285,034 төгрөгийг "Хөдөө аж ахуйн бирж ХХК"-д гаргуулахаар захирамж гарсан боловч төлөлт огт хийгдээгүй байдаг. Иймд 2021.11.11-ний өдрийн 182/ГХ2021/00746 тоот Шүүхийн гүйцэтгэх хуудсын дагуу Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсыг үндэслэн албадан гүйцэтгэх ажиллагааг явуулахаар Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлсэн байдаг. "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022.04.22-ны өдрийн 170 тоот албан бичгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд МЭТУ ХХК-тай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлж өгөх талаар хүсэлт гаргаж, "Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал гаргуулах тухай" гэрээг байгуулсан болно.
		2. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн "Зохигчийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 183/ШШ2022/03519 тоот захирамжаар зээл болон зээлийн хүү

		770,110,000.00 төгрөг, алданги 4,503,324.74 төгрөг, нийт 774,613,324.74 төгрөгийг хариуцагч зөвшөөрч, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-д төлж барагдуулахаар, 2,627,482.83 төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-д гаргуулах шийдвэр гарсан байдаг. Наранзолбоот кашимер ХХК нь 2022/12/31-2025/01/30-ны дотор шүүхийн захирамжид заасан хуваарийн дагуу төлж барагдуулахаар тохирсон ч хуваарийн дагуу төлж барагдуулаагүй. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024.04.09-ний өдрийн 183/Ш32024/08006 тоот Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай захирамж гарсан тул шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, төлбөрийг барагдуулж өгөх хүсэлтийг 2024.08.15-ны өдрийн 236 тоот, 2024.12.05-ны өдрийн 363 тоот албан бичгээр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлсэн болно.
		3. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 181/ШШ2023/03640 тоот захирамжаар хохиролд Х.Баатараас 16,798,375.00 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 241,942.00 төгрөгийг "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-д гаргуулах шийдвэр гарсан байдаг. 2024.09.05-ны өдрийн 251 тоот, 2024.12.05-ны өдрийн 364 тоот албан бичгээр Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газарт Х.Баатарын төлбөрийг барагдуулж өгөх талаар хүсэлт гаргасан болно.
3	Улсын төсөвт төвлөрүүлж буй мөнгөн дүн, 2025 онд Улсын төсөвт төвлөрүүлсэн гүйцэтгэх орлогын даалгавар	"Хөдөө аж ахуйн бирж" ХХК нь сүүлийн 8 жилийн хугацаанд улсын төсөвт татвар, нийгмийн даатгалын шимтгэлд 5,575.41 сая төгрөг, ногдол ашигт 3,336.15 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан. 2025 оны Зорилтын саналд тусгасны дагуу 644.56 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр ажиллаж байна.
4	Ирэх онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүд, санхүүжүүлэх мөнгөн дүн	2025 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөр байхгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 23 50,
Цахим шуудан: info@pcsp.gov.mn,
Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2024 12 04 № А-1/2110

танай _____-ны №_____-т

"ЭРДЭНЭС МОНГОЛ"
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.НАРАНЦОГТ ТАНАА

Асуултын хариуг ирүүлэх тухай

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн ХЭГ/2364 дүгээр албан бичгээр Улсын Их Хурлын гишүүн Д.Мөнхбаясгалангаас ирүүлсэн асуултыг Танд хүргүүлж байна.

Уг асуултад дурдсан төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын олонхи нь "Эрдэнэс монгол" ХХК-ийн харьяанд ажиллаж буй төрийн өмчит хуулийн этгээдүүд байх тул сүүлийн 8 жилийн хугацаанд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн жагсаалт, тэдгээрийн аудитын дүгнэлт, 2025 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлого, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөрийн мэдээллийг нэгтгэн 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт.....хуудастай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

[redacted] 13200[redacted]

А/2024

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК

Эрдэнэс Монгол ХХК-ийн байр, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 7555 3399,
Цахим шуудан: info@erdenesmongol.mn,
Цахим хуудас: www.erdenesmongol.mn

2024.12.27 № 01/1335

танай _____-ны №_____-т

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЦЭНГЭЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн “Асуултын хариуг ирүүлэх тухай” А1/2110 тоот албан бичигтэй танилцлаа.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяанд ажиллаж буй төрийн өмчит хуулийн этгээдийн сүүлийн 8 жилийн хугацаанд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн жагсаалт, улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн, өр төлбөрийн мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн 2025 оны бизнес төлөвлөгөөг эрх бүхий Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэн, батлах үйл ажиллагаа үргэлжилж байгаа тул 2025 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлого, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслийн мэдээллийг одоогоор өгөх боломжгүй байна.

Хавсралт 9. хуудастай.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.НАРАНЦОГТ

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
9024010755 5124913 НД2999

1424063208

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн 01/1223 дугаар албан бичгийн хавсралт

Д/д	Сүүлийн 8 жилд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч	Нэгж	Санхүүжүүлсэн дүн								
				2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
1	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг далд аргаар ашиглах	"Монголрос-цветмет" ТӨҮГ	сая.₮	-	-	-	-	1,448.2	5,662.3	6,746.4	4,959.2	18,816.2
2	Хэрлэн Тооно төслийн ТЭЗҮ-ийн тодотгол	"Эрдэнэс Оюу Толгой" ХХК	сая.₮	-	-	-	-	-	-	-	7,608.0	7,608.0
3	Багануур ХК-ийн бизнес процессын ре-инженеринг, түүнд нөлөөлөх орчны шинжилгээ судалгааны ажил	"Багануур" ХК	сая.₮	45.0	-	-	-	-	-	-	-	45.0
4	Ашиглалтын үеийн геологи хайгуул судалгааны ажил	"Багануур" ХК	сая.₮	-	-	-	-	150.0	-	-	-	150.0
5	ТАМ- н засвар үйлчилгээний байр Хөрөнгө оруулалтын ажил	"Багануур" ХК	сая.₮	-	-	1,518.0	-	-	-	-	-	1,518.0
6	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд археологийн судалгааны ажил	"Багануур" ХК	сая.₮	-	-	-	-	-	5.0	-	-	5.0
7	"ТӨМӨР ДИНОЗАВР" Түүх соёл, аялал жуулчлалын цогцолборын эдийн засгийн судалгааны ажил	"Багануур" ХК	сая.₮	-	-	-	-	-	-	-	19.9	19.9
8	"Багануур" ХК-ийн 110/6 кв-ын Уул дэд станцыг шилжүүлэх ТЗБАХ	"Багануур" ХК	сая.₮	-	-	-	-	-	-	5,537.0	-	5,537.0
9	Асгатын мөнгөний орд төсөл	"Эрдэнэс Монгол" ХХК	сая.₮	-	-	108.8	530.1	23.7	59.3	-	1,586.7	2,308.7

10	Газрын ховор элементийн судалгааны төсөл	"Эрдэнэс Монгол" ХХК	сая.₮	-	-	134.1	258.7	235.7	140.0	-	-	768.3
11	Хийн хоолойн төсөл	"Эрдэнэс Монгол" ХХК	сая.₮	-	-	-	198.5	418.4	646.0	743.1	484.7	2,490.1
12	Шивээ энержи төсөл	"Эрдэнэс Монгол" ХХК	сая.₮	118.6	78.1	236.9	252.5	570.3	23.2	46.7	-	1,279.9
13	25,000 тн/жил хүчин чадалтай давтах аргын ган бөмбөлөгийн үйлдвэрийн төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	17,330.0	-	-	-	-	-	-	-	17,330.0
14	Төвийн төвлөрсөн дулааны шугамд холбогдох төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	1,730.0	-	-	-	-	-	-	-	1,730.0
15	Пресс хайч суурилуулах төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	-	776.2	-	-	-	-	-	-	776.2
16	Шанаган зуух суурилуулах төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	-	4,100.0	-	-	-	-	-	-	4,100.0
17	Усан хөргөлтийн цамхаг суурилуулах төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	-	444.3	-	-	-	-	-	-	444.3
18	Цахилгаан соронзон холигч, хэлбэлзүүлэгч ширээ суурилуулах төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	-	-	2,990.0	-	-	-	-	-	2,990.0
19	Дахин халаах зуухыг дизель түлш рүү шилжүүлэх төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	-	-	1,350.0	-	-	-	-	-	1,350.0
20	Булт шреддерийн тоног төхөөрөмж суурилуулах төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	-	-	-	-	2,210.0	-	-	-	2,210.0

21	"Монгол ган цогцолбор I" төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	-	-	-	-	713.0	-	6,022.9	67.8	6,803.6
22	Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	-	-	-	-	-	-	22.2	74.3	96.5
23	Нойтон баяжуулах, хорголжийн үйлдвэрийн төсөл	"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК	сая.₮	-	-	-	-	-	-	15.0	-	15.0
24	Тавантолгой нүүрс ачих логистикийн төв	"Эрдэнэс Тавантолгой" ХК	тэр.₮	-	-	-	-	81.0	88.7	96.4	43.4	309.6
25	ТТ-ГС болон ТТ-ЗБ төмөр замуудыг холбох төмөр зам	"Эрдэнэс Тавантолгой" ХК	тэр.₮	-	-	-	-	-	218.0	-	-	218.0
26	Тавантолгой-Зүүнбаян төмөр зам	"Эрдэнэс Тавантолгой" ХК	тэр.₮	-	-	357.0	526.0	273.4	127.3	52.4	41.6	1,377.7
27	Нүүрс баяжуулах үйлдвэр	"Эрдэнэс Тавантолгой" ХК	тэр.₮	-	-	-	-	-	95.6	551.1	268.9	915.6
28	Загийн усны хоолойгоос шугам хоолой татах төсөл	"Эрдэнэс Тавантолгой" ХК	тэр.₮	-	-	-	-	-	84.2	14.3	3.4	101.9
29	Кокс-Эрчим хүчний үйлдвэр	"Эрдэнэс Тавантолгой" ХК	сая.₮	-	-	-	-	-	187.0	29.7	50.5	267.2
30	Тавантолгой-Гашуунсухайт төмөр зам	"Эрдэнэс Тавантолгой" ХК	тэр.₮	-	-	490.7	521.3	348.0	412.8	1,199.8	78.3	3,050.9
31	Богдхан төмөр зам	"Эрдэнэс Тавантолгой" ХК	тэр.₮	-	-	-	-	-	130.6	-	-	130.6
32	Газрын тос дамжуулах хоолой	"Эрдэнэс Тавантолгой" ХК	тэр.₮	-	-	-	-	-	59.7	283.2	284.4	627.3
33	Тавантолгой дулааны цахилгаан станц	"Эрдэнэс Тавантолгой" ХК	сая.₮	-	-	-	-	5,692.6	7,034.3	-	-	12,726.9

34	Салхит	"Эрдэнэс Алт Ресурс" ХХК	сая.₮	-	-	-	2,282.5	4,657.2	256.0	654.9	1,475.4	9,326.0
35	Овоот хяр	"Эрдэнэс Алт Ресурс" ХХК	сая.₮	-	-	-	4,652.6	4,733.1	1,296.1	2,620.2	1,310.9	14,612.9
36	Өлзийт овоо	"Эрдэнэс Алт Ресурс" ХХК	сая.₮	-	-	-	-	32.7	53.9	26.3	363.5	476.5
37	Хүрэнцав	"Эрдэнэс Алт Ресурс" ХХК	сая.₮	-	-	-	-	-	-	76.3	71.9	148.2
38	Халзан	"Эрдэнэс Алт Ресурс" ХХК	сая.₮	-	-	-	-	-	-	864.2	2.3	866.5
39	Довжоот	"Эрдэнэс Алт Ресурс" ХХК	сая.₮	-	-	-	-	-	-	62.3	17.5	79.9
40	Мухар хар толгой	"Эрдэнэс Алт Ресурс" ХХК	сая.₮	-	-	-	-	-	-	193.1	11.1	204.1
41	Эрдэс баялгийн нөөц өсгөх төсөл	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	17.5	24.7	12.4	11.1	12.0	17.0	20.8	115.5
42	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн төслүүд	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	235.2	22.0	97.9	154.0	275.4	784.6
43	Ил уурхайд мөчлөгт урсгалт тээвэр нэвтрүүлэх	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	1.7	60.2	23.2	-	30.0	-	115.0
44	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр барьж байгуулах	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	4.1	5.1	-	-	-	9.2
45	Засвар механикийн заводын өргөтгөл, шинэчлэл	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	-	-	5.6	7.9	9.0	22.4
46	Ган бөмбөрцгийн цехийн өргөтгөл, шинэчлэл	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	3.3	-	-	-	-	3.3
47	Химийн төв лаборатори шинээр барьж байгуулах	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	-	-	-	5.9	2.0	7.9

48	Ил уурхайн цахилгаан хангамжийн шугам сүлжээний өргөтгөл	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	5.9	-	-	0.6	0.6	7.1
49	Сэлэнгэ-Эрдэнэтийн ус дамжуулах барилга байгууламжийг өргөтгөж, 3-р шугам хоолойг шинээр барих	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	28.3	57.7	15.8	31.9	0.6	134.3
50	Сэлэнгэ-Эрдэнэтийн ус дамжуулах барилга байгууламж, өргөх станцуудын технологийн автозам	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	-	-	7.5	28.4	5.6	41.5
51	Уурхайчин 3 төсөл /Эко 400 хороллын доторх ИШС зам талбайн тохижилт/	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	14.9	1.1	4.6	3.3	5.2	29.0
52	"Уурхайчин-2.3" орон сууцны хороолол хүртэлх дэд бүтэц барих ажил	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	-	37.7	8.5	5.7	-	51.9
53	Ногоон хөгжлийн төвийн барилга барих ажил	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	8.5	5.0	1.6	-	-	15.1
54	Соёл, спортын "Эрдэнэт" цогцолбор барих ажил	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	11.5	7.6	3.8	4.2	4.0	31.1
55	Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийн төслүүд	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮	-	-	-	-	-	-	17.1	28.1	45.2
56	Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрээс гарах хүхэрт хийнээс элементийн хүхэр ялган авах үйлдвэрлэлийн туршилтын ажил гүйцэтгэх	"Эрдэнэс үйлдвэр" ТӨҮГ	тэр.₮					3.1	7.1	1.6	-	13.6

№	Компанийн нэр	Төрөл		2017	2018	2019	2020	2021	2022	2023	Нийт дүн
1	**“Эрдэнэс Монгол” ХХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	11,243.3	10,447.9	11,394.3	4,488.8	7,406.0	7,751.4	60,241.7	**112,973.4**
			НДШ	932.8	752.3	906.6	846.4	827.1	624.5	1,299.1	**6,188.8**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	4,299.1	107,379.2	24,942.9	248,606.9	42,860.0	12,039.9	114,623.2	**554,751.1**
			Урт хугацаат	254,133.5	166,624.5	241,220.1	963,034.5	1,006,061.2	977,610.6	921,303.5	**4,529,987.9**
2	**“Эрдэнэс Тавантолгой” ХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	213,856.2	391,975.6	696,821.7	471,501.1	207,939.6	990,880.3	2,789,573.2	**5,762,547.6**
			НДШ	4,260.2	6,686.0	11,122.3	12,405.0	12,560.0	16,600.0	31,580.5	**95,214.1**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	460,552.6	285,218.4	311,851.0	1,115,148.7	1,415,927.4	2,523,300.5	2,868,935.8	**8,980,934.4**
			Урт хугацаат	153,165.0	35,596.5	43,375.9	925,705.0	1,644,972.0	1,402,982.1	943,499.2	**5,149,295.6**
3	**“Багануур” ХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	7,935.4	9,784.8	9,962.9	10,291.3	12,414.9	14,907.4	10,856.7	**76,153.4**
			НДШ	6,081.8	9,254.2	6,750.4	7,676.3	5,699.5	9,821.3	17,278.7	**62,562.3**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	85,957.3	116,731.2	135,032.1	142,551.7	139,353.3	164,935.3	130,379.9	**914,940.7**
			Урт хугацаат	72,009.2	49,037.5	38,949.3	23,847.4	45,614.1	56,666.7	112,540.6	**398,664.9**
4	**“Шивээ овоо” ХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	3,047.7	2,621.9	1,710.5	1,483.2	5,933.6	2,915.5	2,861.0	**20,573.5**
			НДШ	2,174.7	1,929.5	661.9	1,032.3	3,363.5	3,646.0	3,229.0	**16,036.8**

		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	63,232.7	43,823.6	51,482.1	52,212.2	49,455.5	57,998.8	77,401.2	**395,606.0**
			Урт хугацаат	46,359.3	76,301.2	76,231.3	75,744.4	84,470.8	95,730.1	91,350.1	**546,187.1**
5	**“Эрдэнэс Оюу Толгой” ХХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	171.4	151.4	150.4	216.8	91.1	3,543.3	3,247.3	**7,571.8**
			НДШ	101.3	101.0	105.0	148.3	238.7	360.0	480.9	**1,535.2**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	1,284.5	1,898.8	2,652.0	3,503.7	6,229.3	7,018.2	8,766.5	**31,353.1**
			Урт хугацаат	5,029.1	5,856.1	6,681.1	7,573.7	9,104.3	7,581.0	6,237.3	**48,062.5**
6	**“Мон-Атом” ХХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	-	55.9	79.2	39.8	32.9	31.6	36.2	**275.7**
			НДШ	-	113.0	251.6	99.7	98.2	105.6	93.2	**761.3**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	-	4,192.8	5,350.4	6,449.0	343.7	314.8	286.3	**16,937.0**
			Урт хугацаат	-	5,682.3	5,877.1	6,453.4	8,076.2	9,399.5	10,690.2	**46,178.6**
7	**“Эрдэнэс Алт Ресурс” ХХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	-	2.4	16.6	22.6	21.2	29.0	58,529.4	**58,621.1**
			НДШ	-	5.4	53.6	77.1	43.0	92.7	1,537.7	**1,809.4**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	-	5.4	2,540.8	3,148.2	5,527.2	2,745.3	182,941.5	**196,908.3**
			Урт хугацаат	-	-	-	-	-	3,453.2	879,747.6	**883,200.8**
8	**“Эрдэнэс Силвер Ресурс” ХХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	-	-	5.4	544.2	1,272.9	6,515.5	-	**8,338.0**
			НДШ	-	-	16.8	780.4	1,149.0	1,308.6	-	**3,254.8**

		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	-	-	580.0	241,587.4	209,179.0	216,399.7	-	**667,746.2**
			Урт хугацаат	-	-	-	936,022.4	782,998.7	830,087.3	-	**2,549,108.3**
9	**“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	541,912.3	571,226.1	757,085.6	782,568.4	912,070.4	1,247,822.8	1,504,158.4	**6,316,844.0**
			НДШ	35,736.9	46,355.3	54,751.5	65,949.6	74,550.0	83,631.0	102,796.8	**463,771.1**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	541,862.3	607,036.1	905,146.3	939,468.5	1,110,232.8	1,696,983.1	710,269.9	**6,510,999.0**
			Урт хугацаат	35,736.9	46,355.3	54,751.5	65,949.6	74,550.0	83,631.0	337,415.3	**698,389.6**
10	**“Монголрос-цветмет” ТӨҮГ**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	9,897.3	12,181.8	28,721.1	38,023.7	99,210.9	10,780.3	14,154.7	**212,969.7**
			НДШ	4,284.6	8,121.5	8,622.5	11,293.3	12,736.1	9,561.1	17,675.2	**72,294.2**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	55,138.5	57,339.9	50,334.5	45,982.7	70,859.2	163,686.1	262,857.4	**706,198.2**
			Урт хугацаат	13,567.3	11,235.6	11,235.6	154.6	202.0	-	364.6	**36,759.6**
11	**“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	2,668.5	895.8	8,494.3	14,130.5	29,505.8	5,567.7	16,636.0	**77,898.8**
			НДШ	244.3	2,244.4	6,056.8	5,633.1	7,945.3	9,107.9	15,200.5	**46,432.3**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	93,826.4	185,697.4	241,845.4	232,268.3	391,245.4	624,120.6	656,961.8	**2,425,965.2**
			Урт хугацаат	241,898.7	194,299.6	162,501.5	259,328.1	240,592.9	181,681.6	192,694.2	**1,472,996.6**
12	**“Цемент шохой” ХХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн	Татвар	-	-	-	-	-	14,141.3	3,280.5	**17,421.9**

		мөнгөн дүн /сая.төг/	НДШ	-	-	-	-	-	10,235.2	4,953.8	**15,189.0**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	-	-	-	-	-	36,204.2	52,963.9	**89,168.1**
			Урт хугацаат	-	-	-	-	-	323,572.7	322,972.1	**646,544.8**
13	**"Гашуунсухайт авто зам" ХХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	891.8	1,126.0	1,504.5	927.4	547.7	826.4	734.0	**6,557.9**
			НДШ	387.5	619.0	875.4	1,016.5	643.6	630.7	846.2	**5,018.8**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	1,697.8	2,560.6	3,877.1	4,661.1	5,708.3	6,073.1	8,058.8	**32,637.0**
			Урт хугацаат	-	-	-	-	-	-	-	-
14	**"Эрдэнэс ҮТП" ХХК**	Улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /сая.төг/	Татвар	-	-	-	-	-	-	-	-
			НДШ	-	-	-	-	-	-	12.7	**12.7**
		Өр төлбөр /сая.төг/	Богино хугацаат	-	-	-	-	-	-	95.0	**95.0**
			Урт хугацаат	-	-	-	-	-	-	324.5	**324.5**